



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/531

Мөрөн сум

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийг 30.1.6, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай 02 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Гишүүд:

Төрийн байгууллагын төлөөлөл:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ажилтны эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлын төлөөлөл:

Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөвсгөл аймаг дахь Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Хөгжимт драмын театрын үйлдвэрчний хорооны дарга

Ажил олгогчийн төлөөлөл:

Ц.Алтаншагай ("Зөөлөн" ХХК-ний менежер)

Н.Отгонбаяр ("Идэр зөөлөн" ХХК-ний захирал)

Б.Мөнгөн-Эрдэнэ ("Денсфорист" ХХК-ний захирал)

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

2. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, төслийн үр дүн нөлөөлөлд үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаж ажиллахыг зөвлөлийн гишүүд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Раднаабүд)-д үүрэг болгосугай.

2.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/206 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

